



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/60

Сүхбаатао сум

24 цагийн үйл ажиллагаатай бүлэг ажиллуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мандал сумын төрийн өмчийн 3 дугаар цэцэрлэгт 24 цагийн үйл ажиллагаатай бүлэг ажиллуулах эцэг, эх, асран хамгаалагчид, байгууллага, орон нутгийн засаг захиргааны хүсэлтийг харгалзан үзэж, тус цэцэрлэгт 24 цагийн үйл ажиллагаатай 1 бүлэг ажиллуулах эрхийг олгож, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтад нэмэлт заалт оруулахыг зөвшөөрсүгэй.

2."Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаанд чанарын амжилт гаргаж, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3.2.1.5, 3.2.2.2, 3.2.2.5, 3.2.4.3, 3.2.5.1, 3.2.5.4 дэх заалтуудын хэрэгжилтийг ханган авлига, ашиг сонирхол, ёс зүй, санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллахыг Мандал сумын төрийн өмчийн 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /Г Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ